



Ц.Өнөрбаян, доктор (Sc.D), профессор  
НХУС-ийн Монгол судлалын төвийн захирал

## БАГШИЙН ХЭЛ ЯРИАНЫ СОЁЛД ТАВИХ ШААРДЛАГА

**Резюме:** В этой статье рассматриваются следующие качества педагогической культуры речи:

1. Правильность речи – ее не единственное но главное коммуникативное качество педагога. Почему главное? Потому что прежде всего правильностью речи обеспечиваются ее взаимопонимаемость, ее единство. Нет правильность не могут “сработать” другие коммуникативные качества.
2. Точность как качество речи основана на связях речь – действительность, слова – предмет
3. Логичность речи основана на связи речь – мышление
4. Чистота речи получает истолкование и может быть описано на базе соотношения речи с литературным языком и нравственной строной нашего сознания
5. Выразительностью речи называются такие особенности ее структуры, которые поддерживают внимание и интерес у слушателя или читателя
6. Богатство речи становится в известной мере и известном отношении, качеством стилеразличающим и стиле образующим
7. Уместность – такой подбор, такая организация средства языка, которые делают речь отвечающей целям и условиям общения

учирзүйтэй байх, цэвэр байх, яруу байх, баялаг байх, оновчтой байх, зохистой байх

Хэл нь хүн төрөлхтөний харилцааны болон тэдний мэдлэг туршлагыг нэг үеэс нөгөө үед өртөөлөн дамжуулагч хүчирхэг хэрэгсэл, оюуны соёлын гайхамшигт бүтээл мөн. Ийм ч учраас хэлнээс ангид нийгэм оршин тогтнох аргагүй. Нийгмийн хөгжил, улс үндэстний оршин тогтноход хэлний үүрэг, хэл ярианы соёл шийдвэрлэх нөлөөтэй байдаг. Тэгвэл монгол хэл нь монголчуудын соёл, иргэншлийн зэвсэг төдийгүй, тэдний нандигнан хайрлаж, арвижуулан баяжуулж байх ёстой үнэт зүйл юм.

Эх хэл, түүний хэрэглээний соёлын бодлого нь улс үндэстний бодлогын салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Даяаршлалын үед үндэсний хэлний талаар төрөөс төдийгүй, иргэн бүрээс тавих анхаарал нэн чухал болжээ. Монгол хэлний тухай хууль баталж түүнийг хэрэгжүүлэх ажлын нааштай эхлэл гарч байгаад монгол хэл судлаачид, эх хэлний багш мэргэжилтнүүд төдийгүй улс үндсээ гэсэн сэтгэлтэй иргэн бүр сэтгэл өөдрөг байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Хэл ярианы соёл эзэмших нь нийгэмд өөрийгөө авч явах, эрдэм мэдлэг эзэмшиж бүтээлч идэвхтэй амьдрах нэг үндсэн нөхцөл мөн. Бүх нийтийн эх хэлний боловсролд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг мэргэжил бол багшийн мэргэжил юм. Тийм ч учраас багшийн хэл ярианы соёлд тавих шаардлага өндөр байх бөгөөд багш хүн бүр хэл ярианы өндөр соёлтой байх үүрэгтэй.

Багшийн хэл ярианы соёл нь түүний мэдлэг боловсрол, сурган хүмүүжүүлэх ур чадвар, ёс зүйн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг, мэдлэг бүтээх хамтын үйл ажиллагааны гол хэрэглүүр юм. Чухамхүү энэ үзлийн үүднээс багшийн хэл ярианы соёлд тавих шаардлага, түүнийг хэрэгжүүлэх арга зүйг онол-арга зүйн талаас нь товч тайлбарлах зорилго тавьсан юм. Багшийн хэл ярианы соёлын үндсэн асуудал нь соёл-соёлт хүн-хэл ярианы соёл-сурган хүмүүжүүлэх харилцааны соёлын харилцан холбоог оновчтой тодорхойлох явдал юм.

Хэл ярианы соёл нь соёлт хүний нэн чухал чанар бөгөөд ийм соёлыг эзэмшүүлэх гол үүргийг багш сурган хүмүүжүүлэгчид хүлээдэг. Өнөөдөр манай иргэдийн хэл ярианы соёлын түвшин харьцангуй доогуур байгаа бол багш нарын хэл ярианы соёлын түвшин доогуур байна гэсэн үг. Багшийн хэл ярианы соёл нь сургалтын удирдахуй, боловсролын үйлчилгээний бүтээмж, үрашиг, суралцагчдын мэдлэг, чадвар, төлөвшилд шийдвэрлэх нөлөөтэй, үндэстний сэтгэлгээг хөгжүүлэх гол хүчин зүйл болдог учраас аливаа улс үндэстний боловсролын бодлогын төвд байх ёстой.

Монгол Улсад багш бэлтгэж ирсэн түүхэнд багшийн хэл ярианы соёлын талаар анхаарч бүх мэргэжлийн багш мэргэжлийн ангид тусгайлан сургалт явуулсан баримт байхгүй байв. Гэтэл бусад улс үндэстний багш бэлтгэдэг сургуульд төдийгүй их дээд сургуулийн бүх ангид “эх хэл ба ярианы соёл” гэсэн хичээлийг заавал үзэхээр сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусган заадаг туршлага байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш мэргэжлийн ангид уг хичээл зааж эхэлсэн нь зохих үр дүнгээ өгч байна.

Багшийн мэргэжил олон талтай бөгөөд хүн хүмүүжүүлэх асар хариуцлагатай байдаг учраас хэл ярианы өндөр соёл эзэмшсэн байх нь түүний соёл, ур чадварын суурь юм. Хэл ярианы харилцаа нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үндсэн харилцаа байдаг. Иймээс багш хүн хэл ярианы соёлын дараах үндсэн чанаруудыг эзэмшсэн байх ёстой. Үүнд :

**1. Зөв байх чанар:** Энэ нь хэл ярианы хамгийн гол чанар. Энэ чанар зөрчигдвөл бусад чанарын тухай ярихын хэрэггүй болно. Хэл яриа зөв байна гэдэг нь тухайн утга зохиолын хэлний найруулгын хэм хэмжээнд туссан хэлний бүтэц, байгуулалтай тохирч байхыг

хэлнэ. Монгол хэлний хөгжлийн өнөөгийн шатанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг дуудлага, үгийн сан-утгазүй, хэлзүйн зүй тогтлыг хэм хэмжээ гэж үзвэл, хэл яриа нь тэрхүү хэм хэмжээнд тохирч байвал хэл ярианы зөв байх чанар хангагдана гэсэн үг. Манайд одоо хүртэл утга зохиолын хэлний суурь аялгуу төв халхын аман аялгууны зөв дуудлагын толь, журамламал хэлзүйн зохиогдоогүй байна. Үүнээс болоод дуудлагын болон хэлзүйн хэм хэмжээ зөрчигдөх тохиолдол түгээмэл гарч байна.

Утга зохиолын хэлний хэм хэмжээг эзэмшүүлэхэд багшийн хэл яриа нэн чухал үүрэгтэй. Багш зөв дуудах, бичих хэм хэмжээг сайн эзэмшсэн байх нь сурагчдын хэл ярианы чадварт үлгэр болдог. Ийм ч учраас багш бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрт “Монгол хэл бичиг, найруулга зүй” гэсэн хичээл оруулсан билээ. Найруулгын хэм хэмжээг тогтоох, эзэмшүүлэх нь зөвхөн хэл шинжлэлийн хүрээнд хамрах асуудал биш сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны зэрэг бусад шинжлэх ухааны анхаарч үзэх чухал асуудлууд билээ.

Хэлний хэм хэмжээ гэдэгт тухайн үеийн утга зохиолын хэлний суурь аялгууны тогтсон дуудлага, үг бүтэх, хувилах зүй тогтол, үг сонголт, өгүүлбэрийн гишүүдийн байр, дараалал, эхийн нэгжүүдийн уялдаа холбоо зэрэг өргөн хүрээтэй асуудал хамрагдана. Утга зохиолын хэлний хэм хэмжээ хэлний хувьсал хөгжлийн хурдыг тогтворжуулж, хэлний дархлааг хадгалдаг гол хүчин зүйл юм.

**2. Оновчтой байх зарчим:** Энэ чанар алдагдвал хэл яриа зорилгоо биелүүлж чадахгүй. Хүний ярьж өгүүлж буй нь бодот юм, бодот ахуйтайгаа тохирч байхыг оновчтой чанар гэнэ. Ийм ч учраас уран үгийн мэргэд, сэтгэгчид “Хэн оновчтой сэтгэж чадна, тэр оновчтой илтгэж чадна”, “Үг нь утга санааг тусгадаг учраас утга санаа ойлгомжгүй бол үг нь ч гэсэн ойлгомжгүй болно” (В.Г.Белинский), “Оновчгүй будлиантай илэрхийлж байгаагийн цаана будлиантай буруу зөрүү сэтгэлгээ л явж байна гэсэн үг” (Н.Г.Чернышевский), “Шинжлэх ухааны болон уран зохиолын хэл хоёрын эн түрүүний шаардлага нь оновчтой тодорхой байх явдал юм” (А.С.Пушкин) гэж тодорхойлжээ.

Энэ чанарыг эзэмшихийн тулд ихийг мэдэх ёстой. Өөрөөр хэлбэл, өгүүлэгч этгээд ярьж байгаа юм үзэгдэл, ухагдахууны тухай маш сайн мэддэг байх ёстой. Хэл яриаг зөв болгохын тулд хэлний тодорхой хэрэглүүрийг оновчтой сонгож хэрэглэх хэрэгтэй. Тухайлбал, үгийг зөв оновчтой сонгож хэрэглэх нь оновчтой тодорхой байх гол нөхцөл (ойролцоо утгат үг, олон утгат үг, ижил үгийг зөв оновчтой сонгох) юм.

Хэл яриа зөв байх, оновчтой тодорхой байх хоёр нь харилцан холбоотой боловч бие биеэсээ ялгаатай. Тухайлбал: зөв байх чанарын гол шалгуур нь хэлэх (хэрэглээ) – хэл (хэм хэмжээ) хоёрын тохироогоор хэмжигддэг бол оновчтой байх чанар нь хэлэх (хэл яриа) нь бодит байдалтайгаа, үг хэллэг нь юм, ухагдахуунтайгаа хэр тохирч байгаагаар хэмжигддэг байна.

Тийм ч учраас багш хүний яриа хэр оновчтой байна гэдэг нь тухайн зааж тайлбарлах гэж байгаа юм үзэгдлийнхээ тухай хэр мэдлэгтэй байгаагийн илэрхийлэл юм. Багш хүн заах зүйлийнхээ талаар сайн мэдлэггүй бол оновчтой тодорхой байх чанар хангагдах боломжгүй. Ер нь ярих гэж байгаа зүйлийнхээ талаар өргөн бөгөөд гүнзгий мэдэхгүй бол хэл яриа оновчтой тодорхой байх чанар бүрэн хэрэгжихгүй. Өөрөөр хэлбэл, явцуу гүехэн мэдлэгтэй хүний хэл яриа оновчгүй, тодорхойгүй байдаг шүү дээ. Тийм ч учраас эрдэмтэн Л.Витгенштейн “Миний ертөнцийн хязгаар бол миний хэлний хязгаар” гэж хэлсэн байдаг. Хэл яриа, бодит байдал хоёрын холбоон дээр тулгуурлаж бодит байдлыг танин мэддэг бөгөөд түүнийгээ үг хэлнийхээ ачаар оюун ухаандаа бэхжүүлж хадгалдаг. Түүнийгээ илэрхийлэхдээ үг хэллэгээ зөв сонгох чадвартай байх ёстой.

3. **Учир зүйтэй байх чанар:** Энэ чанар нь оновчтой байх чанартай нягт холбоотой боловч өөрийн онцлогтой байдаг. Энэ чанарын гол үндэс нь хэл яриа ба сэтгэхүйн харьцаа мөн. Оновчгүй хэл яриа мэдээж учирзүйтэй байж чадахгүй. Үг-ухагдахуун, өгүүлбэр- бодомжийн тохироо зөв байвал учирзүйн чанар биелэгдэнэ. Тухайлбал, нэг өгүүлбэрээр илэрч байгаа санаа бүхэл бүтэн эхээр илэрч байгаа утга агуулгатай дүйж

байх ёстой. Үүнээс үзвэл оновчтой байх нь үгсийн сангийн түвшинтэй холбоотой бол учирзүйтэй байх нь өгүүлбэр, эхийн бүтэц байгуулалтай холбоотой ажээ. Ялангуяа өгүүлбэр дэх үгсийн байрлал зөв байх нь учирзүйтэй байх чанарын нэг үндэс болно.

Хэл яриа учирзүйтэй байна гэдэг нь ярьж тайлбарлаж байгаа бодол санаа, ухаарал илэрхийлэл бүхэн хоорондоо зөв уялдаа холбоотой, дэс дараатай байхыг хэлнэ. Ийм чанар гажихаараа хүнд ойлгомжгүй, өгөөжгүй болно. Учирзүйн дараалал гэдэгт тухайн мэдээлж, тайлбарлаж байгаа зүйл нь учир шалтгаан, үр дагаврын холбоо хамааралтай, орон зай, цаг хугацаа, чухал, чухал бусын эрэмбэ дараалал оновчтой зөв байхыг л ойлгох хэрэгтэй. Энэ чанар алдагдвал, сонсогч, уншигчдад ойлгомжгүй болох эсвэл буруу зөрүү мэдээлэлтэй болох аюултай.

4. **Цэвэр ариун байх чанар:** Хэл –хэлэхүйн харьцаанд үндэслэсэн хэл ярианы харилцааны чанар юм. Өөрөөр хэлбэл, утга зохиолын хэлнээс гажих зүйлийг агуулаагүй ангид байхыг цэвэр байна гэж үзнэ. Хэл ярианы эрүүл саруул чанарт нөлөөлдөг нутгийн аялгууны үг хэллэг, этгээд, бүдүүлэг, албаны модон үг хэллэг, сул илүү үг хэллэгээс ангид байх ёстой. Хараал зүхлийн хатуу үг хэллэг нь багш хүнд хориотой байх. Шинжлэх ухааны нийтлэг нэр томъёоноос өөр харь үг, нэр томъёогоор чамирхах нь хэл ярианы цэвэр ариун чанарт муугаар нөлөөлдөг.

Хэлний цэвэр ариун байх чанарт сөрөг нөлөөтэй нэг үзэгдэл бол харь үг хэллэгээр чамирхах, эсвэл онож сонгоогүй харь үг хэрэглэх үзэгдэл юм. Зайлшгүй шаардлага, хэм хэмжээнд нийцүүлэн авсан харь үг бол тухайн хэлний үгийн санг баяжуулах нэг арга зам болдог. Гэтэл сүүлийн үед гадаад хэл сурч байгаа залуус, холилдсон соёл, сэтгэлгээтэй хүмүүс харь үг хэллэг санаатай, санамсаргүй хэрэглэж эх хэлний цэвэр ариун чанарыг сулруулж байна. Зөвхөн харь үг хэллэг төдийгүй хэлний дархлааны амин сүнс болсон хэлзүйн байгуулал, дотоод бүтцэд харь хэлний бүтэц байгуулал, сэтгэлгээний загвар нэвтэрч байгааг анхаарах шаардлагатай. Тухайлбал, энэ утгаараа, сайн сайхныг хүсмээр байна, өндөр

ач холбогдолтой, төрөлт явагдаж байна, манай гэр бүлийн асуудал, мал маллах үйл ажиллагаа гэх мэт харь загвартай, албаны болхи үг хэллэг ярианы хэлэнд төдийгүй утга зохиолын хэлний төрөл бүрийн найруулгад тохиолдох боллоо. Ер нь онож сонгоогүй үг хэллэг хүүхэд залуучуудын хэл ярианд сөрөг нөлөөтэй учраас багш сурган хүмүүжүүлэгчид хэл яриа, бичиг соёлдоо онцгой анхаарч байх ёстой.

5. **Уран яруу байх чанар:** Энэ нь хэл яриа сонсогчийн мэдрэмж, сэтгэл хөдлөл, сонирхол хэрэгцээнд нөлөөлөх чанар юм. Багш, хүний сэтгэлзүйг мэдрэх, татах чадвар нь яруу байх чанарын үндэс болдог. Энэхүү чанар нь хэл яриа ба ухамсрын харилцан зохицол дээр тулгуурлана.

Хэл ярианы үр ашгийг бүхэлд нь үнэлэх шалгуур үзүүлэлт юм. Хэл ярианы чадвар, өгүүлэгчийн үгийн урлаг, уран яруу илтгэх чанарыг гол шинж болдог. Хэл ярианы гоозүйн тал, дуудлагын өнгө аясыг энэ чанарыг хэр эзэмшсэнээр үнэлнэ. Хэт чамирхал, уран үгээр наадах нь хэл ярианы соёлд сөрөг нөлөөтэй. Орон, цаг, сонсогчийн мэдлэг туршлага, мөн харилцагчийн сэтгэлзүйн уур амьсгалыг харгалзах нь чухал байдаг. Тухайлбал, өвчтөний дэргэд магтаал сайшаал, сурагчдын дэргэд хараал зүхэл, баярын ширээн дээр доромжлол харш гэдгийг санах хэрэгтэй. Өгүүлэгчийн сэтгэлийн аяс, ярьж байгаа зүйлдээ хандах хандлага энэ чанарт шууд холбогдоно.

Амьдрал дээр зарим хүний яриа сонирхол татаж, сэтгэл хөдөлгөм, заримынх нь залуу хүргэж, уйтгар төрүүлж байдаг шүү дээ. Тухайн хүн ярьж байгаа зүйлийнхээ талаар мэдлэг сайтай, сонсогчоо мэдрэх чадвар нь онцгой, юу ярьж, хүний оюун санаанд яаж нөлөөлөх вэ? гэсэн өвөрмөц арга барилтай, харилцааны ур дүйтэй бол яриа, зөвлөгөө чанартай өгөөжтэй болдог. Энэ чанарыг эзэмших нь багш хүний эрхэм зорилго байх ёстой юм. Ер нь хэл ярианы уран яруу байх чанар бол хэнтэй, хэзээ, хаана, юуг, ямар зорилгоор, яах гэж харилцахаас шалтгаална. Мөн тухайн хүний биеийн хэл, дуу хоолойн өнгө, сэтгэл санааны байдал нь багшийн хэл ярианы уран яруу байдалд шууд нөлөөтэй байдаг.

6. **Баялаг (олон талт) чанар:** Энэ чанар нь эрдэмтэн мэргэд, зохиолч уран үгийн дархад багш сурган хүмүүжүүлэгчдийн хэл ярианы соёлд эн тэргүүнд авч үздэг шаардлага юм.

Энэ чанарын гүн ухааны үндэс нь хэлэхүй-хэл, хэлэхүй-ухамсрын харилцан хамаарлаас гардаг. Мэдээж уран зохиолын найруулга нь албан бичиг, сонин нийтлэл, эрдэм шинжилгээний найруулгаас баялаг чанараараа давуу байдаг. Баялаг чанарын гол бүрэлдэхүүн нь үгийн сангийн, утгын, өгүүлбэрзүйн, аялгын баялаг чанарууд юм.

Үгийн сангийн баялаг чанарыг дараах аргачлалаар хэмждэг.

Коэффициент үглэвэр (лексема)  
(Үгийн сан) = тухайн эхэд байгаа бүх үгийн тоо

Энэ нь яригч, бичигч хүний үгийн сангийн баялаг чанарыг баримжаалан тогтоодог түгээмэл хэрэглэгддэг арга юм. Үүнд: үглэвэр (лексема) гэдэг нь тухайн эх (текст)-эд орсон давхардаагүй үгийн тоог эхэд орсон бүх

/давхардсан/ үгэнд хувааж гаргана. Ийнхүү 1.0 байвал үнэмлэхүй дээд амжилт бодит байдал дээр ийм үзүүлэлт бараг байхгүй. Харин 1.0-д ойртуулахыг эрхэм зорилгоо болгох хэрэгтэй.

Баялаг чанарыг бууруулдаг гол шалтгаан нь эхэд нэг үгийг ойрхон давтах, нэг язгуурт үгийг ойрхон давтах, нэг хэв шинжийн өгүүлбэр, хэлзүйн хэлбэр олон хэрэглэх зэрэг болно.

7. **Зохистой /оновчтой/ байх чанар:**

Энэ чанарын гол санааг “Өнөө хэлбэл зохих зүйлийг өнөөдөр л хэл, үлдсэнийг нь хойш тавьж зохистой цагт нь хэл” /Хораций/ гэсэн үгээр тодорхойлж болно. Зохистой хэл яриа нь мэдээллийнхээ сэдэвт яв цав нийцсэн, учирзүй, сэтгэл хөдөлгөх агуулгатай, уншигч, сонсогчдынхоо хэрэгцээ, сонирхлыг татсан, мэдээлэх, хүмүүжүүлэх, гоо зүйн таашаал олгох зорилгод тохирсон байна. Багш сурагчдынхаа нас, сэтгэхүйн онцлогт тохирсон харьцааны соёл эзэмших, сурагчдаа орчин, цаг үеийг нь олж урамшуулах, зэмлэх, дэмжих, өдөөх, зөвлөх зааварлах чадвар эзэмших ёстой.

Зохистой байх чанар нь хэлэхүй ба харилцааны орчин нөхцөлийн харилцан хамаарлаас шалтгаална. Энэ чанар нь оновчтой, тодорхой, цэвэр ариун, уран яруу байх чанаруудтай шууд шүтэн барилдсан харьцаатай байна.

Харилцах зорилго, нөхцөл байдал, орчин, цаг хугацаа, нас, сэтгэхүйн онцлогийг зөв тооцож хэлний хэрэглүүрийг зөв сонгох чанар юм. Өөрөөр хэлбэл, мэдээлэх, хүмүүжүүлж төлөвшүүлэх, сургах, зөвлөх, зааварлах, таашаал мэдрэмж өгөх зэрэг зорилготойгоор хэл яриа нь хэр дүйж байна вэ? гэдгийг анхаарна гэсэн үг юм.

8. Багшийн дуу хоолойн өнгө, хурд, эрчим, хүч, уян хатан байдал нь хэл ярианы соёлын чухал тал юм.

### ДҮГНЭЛТ

Харилцан яриаг хөтлөх жолоодох чадвар нь багшийн хэл ярианы соёлд чухал нөлөөтэй. Эцэст нь багшийн хэл ярианы соёл нь боловсролын үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэх нэг чухал хүчин зүйл, мэргэжлийн ур чадварын гол шалгуур, боловсролын үйлчилгээ үзүүлэх гол хэрэгсэл мөн. Ийм ч учраас багш бэлтгэдэг ангиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт “Багшийн хэл ярианы соёл” гэсэн хичээл оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Актуальные проблемы культуры речи. (1970), Москва

Будагов. Р.А. (1974), Человек и его язык. Москва

Кевин Хоган. (2011), Үнэмшүүлэн итгүүлэхийн сэтгэл зүй Соёмбо принтинг. ХХК. Улаанбаатар

Львов. М.Р. (1999), Словарь-справочник по методике преподавания русского языка. Издательский центр “Академия”, Москва

Отгонсүрэн. Д. (1974), Уран зохиолын хэлний тухай. Улаанбаатар,

Педагогический энциклопедический словарь. (2008), Научное изд-во “Большой российская энциклопедия” Москва

Сүхбаатар.Ц. (2007), Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар